



**“ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ” ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 12 өдөр

Дугаар А/14

Улаанбаатар хот

**Ёс зүйн дүрэм батлах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.10 дахь заалт, Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв ОНӨААТҮГ-ын “Дүрэм”-ийн 5 дугаар зүйлийн 5.7.3 дахь заалт, “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 1 дүгээр зүйлийн 1.2.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Үйлдвэрийн газрын нийт ажилтанууд дагаж мөрдөх ажилтны ёс зүйн дүрмийг хавсралтаар баталсугай.
2. Батлагдсан дүрмийг хэрэгжүүлж ажиллахыг Үйлдвэрийн газрын нийт ажилтнуудад үүрэг болгосугай.
3. Ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Ёс зүйн зөвлөлд даалгасугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын хэлтсийн дарга Ц.Болормаад үүрэг болгосугай.

ДАРГА  Б.БАТТУЛГА

0025040608  
140793 СБТ28239

## ЁС ЗҮЙН ДҮРЭМ "ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ" ОНӨААТҮГ

### НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1.Ёс зүйн дүрмийн зорилго: Ажилтны өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээг тогтоон хэвшүүлэх, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэн тэгш хандах, эрхэлсэн ажлаа мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэх болон энэхүү дүрмээр тогтоосон хэм хэмжээг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг ногдуулахад энэхүү дүрмийн зорилго оршино.

1.2.Үйлчлэх хүрээ: Энэхүү дүрэм нь Монгол Улсын Үндсэн хууль болон байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа дүрэм, журам, бусад хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийн хүрээнд "ТҮЛШ ХЭРЭГЛЭГЧДЭД ҮЙЛЧЛЭХ ТӨВ ОНӨААТҮГ-ын үндсэн ажилтнууд, гэрээт ажилтнуудад үйлчилнэ.

1.3.Ёс зүйн зөрчил гаргасан ажилтнуудад хариуцлага тооцохтой холбогдсон харилцааг энэхүү дүрэм болон ёс зүйн зөвлөлийн ажиллах журмаар зохицуулна.

1.4.Ажилтны ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тухай гомдол, мэдээллийг хүлээн авч, түүний үндэслэлийг шалган тогтоож, дүгнэлт гаргах үүрэг бүхий байнгын Ёс зүйн зөвлөл ажиллана. Ёс зүйн зөвлөл түүний ажиллах журмыг Үйлдвэрийн газрын тушаалаар батална.

### ХОЁР. ЭРХЭМ ЗОРИЛГО, ҮНЭТ ЗҮЙЛС, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

2.1.Эрхэм зорилго: "Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв" ОНӨААТҮГ (цаашид "Үйлдвэрийн газар" гэх) нь Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах, угаарын хийн хордлогоос урьдчилан сэргийлэх зорилгоор хатуу болон хийн түлш хэрэглэгч айл өрхүүдийн хэрэглээнд хяналт тавих, пийшин, яндан, зуухны битүүмжийг шалгах, засвар үйлчилгээ үзүүлэх, зөв галлагааны горим болон угаарын хийнээс сэргийлэх санамж, зөвлөмжийг түгээх, судалгаа мэдээлэл нэгтгэх, сургалт зохион байгуулах, угаарын хий мэдрэх төхөөрөмжийн ашиглалтад хяналт тавих, хяналтын системээр тасралтгүй хянах замаар эрсдэлээс урьдчилан сэргийлж, нийтийн аюулгүй, эрүүл орчныг бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг тууштай хэрэгжүүлэх эрхэм зорилготой.

2.2.Ажилтан нь "Түлш хэрэглэгчдэд үйлчлэх төв" ОНӨААТҮГ-ын үнэт зүйлсийг эрхэмлэн дээдэлнэ. Үйлдвэрийн газрын үнэт зүйлс нь:

2.2.1.Шударга байх;

2.2.2.Хуулийн хүрээнд ажиллах;

2.2.3.Мэргэшсэн, хариуцлагатай байх;

2.2.4.Харилцан хүндэтгэлтэй харилцаа;

2.2.5.Сахилга баттай байх;

2.2.6.Мэдлэг, инновацыг эрхэмлэх, бүтээлч байх;

2.2.7.Аюулгүй байдлыг байнга хангах;

2.2.8.Шуурхай байх;

2.2.9.Нэгдмэл байхыг эрхэмлэх болно.

2.3. Үйлдвэрийн газрын ажилтан үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтална.

Үүнд:

- Хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх;
- Хүнлэг, энэрэнгүй, шударга ёсыг дээдлэх;
- Хувийн ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;
- Хэрэглэгчдэд чин сэтгэлээсээ үйлчлэх;
- Ёс суртахууны үлгэр дуурайлалтай ажиллах;
- Мэргэжлийн нэр хүнд, үнэ цэнийг хамгаалах;
- Хуулийг чанд сахих, хариуцлагатай байх; Аливаа ялгаварлан гадуурхалтаас ангид байх, тэгш байдлыг хангах;
- Мэргэжлийн ур чадвартай байх, бүтээлч хандлагатай байх;
- Хараат бус байж гаднын нөлөөнд автахгүй байх;
- Байгууллага болон хувь хүний нууцтай холбоотой ажил үүрэг гүйцэтгэсэн тохиолдолд ажил үүргийн дагуу олж мэдсэн байгууллага болон хувь хүний нууцыг чандлан хадгалах;

2.4. Ажилтан өөрийн үйл ажиллагаандаа компанийн үнэт зүйлс, баримтлах зарчмыг удирдлага болгон ажиллана.

#### ГУРАВ. АЖИЛТАНД ТАВИГДАХ НИЙТЛЭГ ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭ

3.1. Ажилтан үйл ажиллагаандаа энэ дүрмийн 2.2, 2.3-т заасан үнэт зүйлс, зарчимд нийцсэн дараах нийтлэг ёс зүйн хэм хэмжээг чандлан сахих үүрэгтэй. Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль зүйн акт, байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа соёл, дэг, дүрэм, журам, зааврыг чанд баримтлах

3.2. Төрийн болон байгууллагын, хувь хүний нууцын тухай хуулиар хамгаалагдсан нууцыг хамгаалах.

3.3. Үйл ажиллагаа явуулахдаа хамтран ажиллагчид, хэрэглэгчид, бусад хүмүүсийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, эрүүл мэндийн байдал, бэлгийн хандлагаар нь ялгаварлан гадуурхахгүй байх

3.4. Ажилтан нь ажлын цагаар болон нийтийг хамарсан олон нийтийн ажил зохиох үед хамтран ажиллагчид болон хэрэглэгчид, бусад хүмүүсийн нэр төрд халдах зорилгоор худал мэдээлэл нийтэд тараах, гутаан доромжлох, гүтгэх, заналхийлэх, биеэ зүй бусаар авч явах, бүдүүлэг авир гаргах, дарамтлах зэрэг аливаа үйлдэл гаргахгүй байх.

3.5. Ажилтан ажил үүргээ чин шударгаар гүйцэтгэн, ажилдаа хариуцлагатай хандах, байгууллагын нэр хүндийг ямагт дээдэлж, түүнд харшлах аливаа үйлдлийг цээрлэх, хамт олны нэгдмэл байдлыг алдагдуулах үйлдэл гаргахгүй байх.

3.6. Ажлын байранд тавигдах шаардлагыг хангасан мэргэжил, ур чадвараа байнга дээшлүүлэхийн төлөө өөрийн хүчээ дайчлан бүтээлчээр ажиллаж, аливаа асуудалд шинэлэг сэтгэлгээгээр хандаж, ажлын дэвшилтэт арга хэлбэрийг илэрхийлдэг, мэдлэг чадвараараа шударга өрсөлддөг байх.

3.7. Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх, албан тушаалаа урвуулан ашиглах, албан тушаалын бүрэн эрхээ ашиглан бусдыг дарамтлах, айлган сүрдүүлэх, эрхшээлдээ байлгах, хууран мэхлэх, хавчин гадуурхаж хясан боогдуулахгүй байх.

3.8. Үйлдвэрийн газрын эд хөрөнгө, техник хэрэгсэл, албаны мэдээллийг хувийн зорилгоор ашиглах, ашиг олох, бусдад дур мэдэн шилжүүлэх, устгах зэрэг үйлдэл гаргахгүй байх.

- 3.9.Ажил олгогчийн зөвшөөрөлгүйгээр өөр байгууллагад давхар ажил үүрэг гүйцэтгэхгүй байх.
- 3.10.Хуурамч бичиг баримт ашиглан ажил үүрэг гүйцэтгэхгүй байх,
- 3.11.Үйлдвэрийн газрын үйл ажиллагаатай холбоотой нотлогдоогүй, компанийн нэр хүндэд халдахуйц худал мэдээллийг тараахгүй байх,
- 3.12.Мэдлэг чадвар, хувийн зохион байгуулалтаараа бусдыг үлгэрлэн дагуулж ямагт манлайлагч байх, зөв соёлч боловсноор биеэ авч явах, ажлын цагийг үр бүтээлтэй, бүрэн ашиглах,
- 3.13.Өөрийн удирдлагадаа байгаа албан хаагчдын өмнө нэр хүнд, ажил хэргийн үлгэр жишээг үзүүлэх
- 3.14.Албан ажилд шаардлагатай мэдээллийг санаатайгаар нуун дарагдуулах, удирдлагын шийдвэр гаргах үйл ажиллагаанд саад учруулахыг цээрлэх
- 3.15.Албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын байранд согтууруулах ундаа, мансууруулах бодис хэрэглэх, бүдүүлэг зан авир гаргах, зүй бус үг хэллэг хэрэглэх, олон нийтийн газар мөрдөх дэг журмыг сахих.
- 3.16.Албан үүргээ гүйцэтгэж байхдаа болон ажлын байранд буюу ажлын цагаар, албан томилолтоор яваа үедээ согтууруулах ундаа хэрэглэхгүй байх, этгээд байдлаар хувцаслахгүй байх
- 3.17.Ажил үүрэг гүйцэтгэх үедээ мэргэжлийн болон ажлын үнэмлэхийг биедээ заавал авч явах, бусдын орон байр, эд хөрөнгөд нэвтрэх, бусдад шаардлага тавих үедээ өөрийгөө танилцуулж бичиг баримтаа үзүүлж байх

#### ДӨРӨВ. АЖИЛТНЫ ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ

4.1.Үйлдвэрийн газрын ажилтнуудын ёс зүйн зөрчил гэдэг нь Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/, бусад хууль тогтоомж, дотоод журам, эрх бүхий байгууллагаас баталж гаргасан эрхийн акт болон энэ дүрмээр тогтоосон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн үйлдэл эс үйлдэхүйг зөрчилд тооцно.

#### ТАВ. ЁС ЗҮЙН ЗӨРЧИЛ ГАРГАСАН АЖИЛТАНД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

- 5.1.Ёс зүйн дүрмийг болон ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн ажилтанд зөрчлийн шинж байдлыг харгалзан ёс зүйн дараах хариуцлага хүлээлгэнэ.
- 5.1.1.Уучлал гуйхыг үүрэг болгох,
- 5.1.2.Захиргаанаас анхааруулах,
- 5.1.3.Сахилгын шийтгэл ногдуулах санал гаргах,
- 5.2.Тухайн ажилтан сайн дураараа албан тушаалаасаа чөлөөлөгдөх нь ёс зүйн хариуцлага хүлээсэнд тооцогдоно.
- 5.3.Үйлдвэрийн газрын дарга нь ажилтныг ёс зүйн хэм хэмжээ зөрчсөн тухай Ёс зүйн зөвлөлөөс гаргасан дүгнэлтэд үндэслэн холбогдох хууль тогтоомж, Хөдөлмөрийн дотоод журамд заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.